



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/76

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дүгээр зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 –ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Улаан загалмай хамтын ажиллагааны хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүмүүнлэгийн зарим чиг үүргийг аймгийн Улаан загалмай хороогоор гүйцэтгүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Гамшиг, Эрүүл мэнд, Халамж, Хүүхэд залуучуудын хөтөлбөрийн хүрээнд хүмүүнлэгийн тусламж хүргэх, анхны тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах, сайн дурын идэвхтэн бэлтгэх, авлагагүй цусны донорыг нэмэгдүүлэх, сайн үйлсийн сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, гамшгийн бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх чиглэлд зарцуулахаар 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Батлагдсан удирдамж, төсвийн дагуу санхүүжилтийг тухай бүр Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ